



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/16

Лун


2018 оныг "Хариуцлагын жил"
болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Засгийн газрын "2018 оныг Хариуцлагын жил болгон зарлах тухай" "2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 32 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын "2018 оныг Хариуцлагын жил болгон зарлах тухай" 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/83 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласугай.
2. "Хариуцлагын жил"-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01, Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар, албан даалгавар, "Хариуцлагын жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэгжилт үе шат бүрд дүгнэж, дутагдал, зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдад хариуцлага тооцож захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга /В.Гантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХ-ЭРДЭНЭ



Баянтал сумын Засаг даргын 2017 оны
сарын 07 өдрийн 07 тоот захирамжийн
нэгдүгээр хавсралт

"ХАРИУЦЛАГЫН ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.04.09.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах эзэн
1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах.			
1.1.	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган аймгийн ТЗУХэлтэс, ХШУДАХэлтэст тайланг хугацаанд нь хүргүүлэх	44 арга хэмжээг чанартай зохион байгуулан 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
1.2.	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж, аймгийн ТЗУХэлтэс, ХШУДАХэлтэст тайланг хугацаанд нь хүргүүлэх.	27 арга хэмжээг чанартай зохион байгуулан 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
1.3.	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган аймгийн ТЗУХэлтэс, ХШУДАХэлтэс, сумын ИТХ-д тайланг хугацаанд нь хүргүүлэх.	112 арга хэмжээг чанартай зохион байгуулан 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
1.4.	Сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж, аймгийн ТЗУХэлтэс, ХШУДАХэлтэс, сумын ИТХ-д тайланг хугацаанд нь хүргүүлэх.	84 арга хэмжээг чанартай зохион байгуулан 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
2. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах.			
2.1.	Байгууллага бүр иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах.	15 хоногийн хугацаанд өргөдөл, гомдлыг 100 хувь шийдвэрлэж, хариу хүргүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
2.2.	Сумын ЗДТГазарт ирсэн өргөдөл гомдол санал, хүсэлтийг шуурхай	15 хоногийн хугацаанд өргөдөл,	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт

	шийдвэрлэнэ.	гомдлыг 100 хувь шийдвэрлэж, хариу хүргүүлсэн байна.	байгууллагууд
3. Төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх.			
3.1.	Төрийн захиргааны бүх байгууллагууд ажиллагсадтайгаа үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр дүгнэж гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох.	Үнэн , бодитой дүгнэсэн байна. Нийт албан хаагчидтай гэрээ байгуулан, үр дүнг тооцсон байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд
3.2.	"Хариуцлагын жил"-ийн хүрээнд Төсөвт байгууллагууд 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланг Зөрчилгүй санал дүгнэлт авах, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох.	Удирдлага, албан тушаалтан ажилдаа хариуцлагатай хандсан байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд, Санхүү алба
3.3.	Санхүүгийн Аудитын тайланг, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид , Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үр дүнг тайлагнах.	Санхүүгийн тайланг хурлаар хэлэлцүүлэн үр дүнг тооцсон байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд, Санхүү алба
3.4.	Байгууллага бүр Санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын нэгжтэй болж анхан шатны хяналтыг сайжруулах.	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулсан байна.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд, Санхүү алба
4. 2018 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах.			
4.1.	Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.	Төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувь байна.	Сумын ЗДТГазар, Санхүү алба, ХАА-н хариуцсан мэргэжилтэн
4.2.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж, хугацаанд нь хүлээн авна.	Хөрөнгө оруулалтыг 100 хувь зориулалт, тоо хэмжээний дагуу чанартай гүйцэтгэсэн байна.	Сумын ЗДТГазар, Санхүү алба, ХАА-н хариуцсан мэргэжилтэн
4.3.	Орон нутгийн хөгжлийн сан болон бусад холбогдох төсвөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний тайланг иргэдэд тавьж, 2019 оны ОНХСангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдээр хэлэлцүүлж, эрэмбэлүүлэх.	Холбогдох хууль, заавар, журмыг хэрэгжүүлсэн байна.	Сумын ЗДТГазар, Багийн Засаг дарга нар, ХАА-н хариуцсан мэргэжилтэн
5. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.			
5.1.	"Сахилга хариуцлага дэг журмыг	Албан даалгаврыг	Сумын ЗДТГазар,

	чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01, аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж, үр дүнг тайлагнах.	100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. Хагас, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнасан байна.	Бүх төсөвт байгууллагууд, Санхүү алба
6. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалах.			
6.1.	Иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг тасралтгүй зохион байгуулах.	Үр дүнтэй байх.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
6.2.	Иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Үр дүнтэй байх.	Сумын ЗДТГазар, Бүх төсөвт байгууллагууд, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн